



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/07


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай” 9/36 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 01 дүгээр зөвлөмжийн дагуу “Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажлын судалгааг хийх, тохижилтын ажлын дүнд бий болсон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил ашиглалтын байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын бусад зардлаас санхүүжиж буй тохижилтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажил”-ын гүйцэтгэлд хяналт тавьж, явц үр дүнг тайлагнан ажиллахыг Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс /М.Гансэлэм/-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах 50,000,000 /Тавин сая/ төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

